



**ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

*Төлөвлөгөөг хянасан:*

***Төсвийн ерөнхийлөн захирагч***

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА  
(албан тушаал )

.....  
(гарын үсэг)

/У.БОЛДХҮҮ/

.....  
(огноо)

*Төлөвлөгөө баталсан:*

***Төсвийн төвлөрүүлэн захирагч***

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
(албан тушаал )

.....  
(гарын үсэг)

/М.ОТГОНБАЯР/

2024.11.20  
(огноо)

**ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>ЗОРИЛГО. УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.</b>							
<b>Зорилт1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.</b>							
1.1	Тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо хувь,	34,5%	40%	Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг олговол зохих 73598 иргэнээс 2024 оны жилийн байдлаар 31553 иргэнд тоон гарын үсэг буюу 42,8 хувьд нь олгоод байна.	100
1.2	Хэлтсийн үйлчилгээнд шинжилгээ хийх	-	Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо	0	1	Бүртгэгч нарын бүртгэлийн үйл ажиллагаанд өгөгдлийн шинжилгээ хийхэд эд хөрөнгийн бүртгэгчид 7 хоногт дунджаар 298-322 бүртгэл буюу нэг бүртгэгчид 41-53 бүртгэл, өдөрт 15-20 бүртгэл, иргэний улсын бүртгэгч нарын 8 төрөлд шинжилгээ хийхэд 7 хоногт дунджаар 468 бүртгэл буюу нэг бүртгэгчид 117 бүртгэл /шилжилт хөдөлгөөн ихтэй үед/ хуулийн этгээдийн бүртгэгч 7 хоногт 14 бүртгэл буюу 80% нь нэрийн баталгаажилт хийж байна. Өдөрт үйлчилгээний танхимаар 330-502 иргэн үйлчлүүлж байгаа бөгөөд 14 цагаас хойш иргэдийн хөдөлгөөн ихсэж байгаа нь	100

						шинжилгээгээр харагдаж байна. Иймд бүртгэгч нарын ачаалал нэг хэвийн бөгөөд компани тусгай ажил үүргийн дагуу нэмэгдэж байна гэсэн судалгаа шинжилгээ гарсан.	
1.3	Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм журам зааврыг холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэдэд сурталчлах		Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн сурталчилгааны тоо	3	5	Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулиар бүртгэлтэй холбоотой мэдээлэл сурталчилгааг орон нутгийн 8 телевизээр тус бүр 2 удаа, контент хэлбэрээр 3 удаа, аймгийн Амарын талбайд 2 өдөр иргэдэд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуулиар 58 иргэнд гарын авлага материал тарааж, 32 иргэний дунд “АХА” тэмцээн зохион байгуулж гарын бэлэг өглөө. Мөн тус хэлтсийн 7035-8989 дугаарын лавлах утсаар жилийн турш давхардсан тоогоор 2784 иргэнд иргэний бүртгэлийн тухай хуулиар, 594 иргэнд эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар мэдээлэл сурталчилгаа хийлээ.	100
1.4	Бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр иргэдэд хүргэх		цахим машины тоо	2	2	Аймгийн засаг даргын тамгын газрын “Цахим төв”-ийн Дөт машинаар цаг хугацаа харгалзахгүйгээр 3657 иргэнд, хэлтсийн үйлчилгээний танхимын Дөт машинаар 6715 иргэнд тус тус цахим бүртгэлийн үйлчилгээг, мөн 4G модемоор 437 дугаар нээлттэй хорих ангид 1 өдөр ажиллаж тоон	100
			үйлчилгээний тоог хувиар	100%	100%		

						гарын үсэг, иргэний үнэмлэх дахин авах 12 иргэнд бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь үзүүллээ. Жилийн хугацаанд зээлийн гэрээ батлуулсан газар барьцаалсан 3871, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан 9332 иргэнд эд хөрөнгийн 309 лавлагаа мэдээллийг цахимаар олголоо.	
1.5	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд хүргэх, контент бэлтгэх	-	Сурталчилсан мэдээ мэдээлэл, сурталчилгааны тоо, Бэлтгэсэн контентийн бэлтгэх	8	10	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн хууль журмыг Аймгийн засаг даргын шуурхай зөвлөгөөнд 2 удаа, аймгийн хуулийн хэлтсийн “Хуулийн цаг” нэвтрүүлгээр 7 удаа, нээлттэй хаалганы “Про Боно” өдөрлөгөөр-3 тус тус иргэдэд сурталчилсныг 1500 иргэн үзэж лайк, шэйр хийсэн нь иргэд зөв ойлголт мэдээлэлтэй болж бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломж бүрдэж байна. Өөрсдийн нөөц бололцоогоор иргэний улсын бүртгэлтэй холбоотой 8 контент, эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой-7, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой-1, авлигаас ангид байх тухай-1 контент бэлтгэн олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэснийг 1250 иргэн үзэж танилцсан байна.	100
<b>Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.</b>							
2.1	“Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	-	Зөврийн тоног төхөөрөмжөөр үзүүлсэн үйлчилгээний	0	100%	Зөврийн тоног төхөөрөмж ашиглан шинээр байгуулагдсан 4 багт нийт 17 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ. Өдөрлөгөөр	100

			тоо хувиар			иргэний бүртгэлийн чиглэлээр 2689 иргэнд, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 152 иргэнд, мөн Жаргалант сумын 253 иргэнд бүртгэлийн үйлчилгээг зөөврийн тоног төхөөрөмж 4G ашиглан 100 хувь үйлчилгээ үзүүллээ.	
2.2	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia, E-business/ -ээр үзүүлэх бүртгэлийн үйлчилгээг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулах	-	Сурталчилсан мэдээ мэдээлэл, сурталчилгааны тоо	8	12	Иргэдэд цахим үйлчилгээ үзүүлэх E-buziness, E-mongolia системээр бүртгэлийн үйлчилгээг хэрхэн бүртгүүлэх зааварчилгаа мэдээлэл хүргэх шторк, нийтлэлийг хэлтсийн цахим хуудас болон нийгмийн сүлжээгээр нийт 33 удаа байршуулж нийтэд түгээн сурталчиллаа. E-buziness системээр 1642 аж ахуйн нэгжийн нэрийн баталгаажилт болон цахим гэрчилгээ олголоо.	100
		-	Цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо хувиар/	100%	100%		
2.3	Төрийн нэгдсэн үйлчилгээний төвд 24/7 цэг байгуулах, иргэдэд цахим үйлчилгээг ойртуулах		Үзүүлсэн үйлчилгээний тоо хувиар	0	100%	Аймгийн Засаг даргын тамгын газарт болон хэлтсийн байранд 24/7 цахим төвийг тус тус байгуулж иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулж цаг хугацаа харгалзахгүй үйлчилгээ авах боломжийг бүрдүүлснээр жилийн эцсийн байдлаар бүртгэлийн киоскоор 16 төрлийн 10372 лавлагаа, 619 тоон гарын үсгийг олгосон. Төлбөрийн гэрэгэ киоскоор иргэний улсын бүртгэлийн 8771, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 3732, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 781, лавлагааны 5431 болон 193 бүртгэлийн үйлчилгээний торгуулийн төлбөр тус тус төлөгдөж үйлчилгээг 100 хувь	100

						үзүүллээ.	
2.4	Хууль хяналтын байгууллагад олгож буй мэдээлэл лавлагааг албан бичиг баримт боловсруулалтын E-office, E-doc цахим программаар олгох		Үзүүлсэн лавлагаа, мэдээллийн тоо хувиар	100%	100%	Хууль хяналтын байгууллагад 2024 оны жилийн эцсийн байдлаар 661 лавлагаа тайлбар хүргүүлсэн бөгөөд E-оффисс, E-doc систем болон цаасаар хүргүүлсэн албан бичиг нийт 1034 байгаа нь мөн оны өмнөх үетэй харьцуулахад цаасаар явсан бичиг 5,4 хувиар буурсан нь E-оффисс, E-doc программаар албан бичиг баримт хүргүүлж байгаатай холбоотой цаас хорны хэмнэлтэй ажилласан.	100
2.5	Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах	-	Цахимжуулсан иргэний бүртгэлийн эх нотлох баримтын тоо хувиар	100%	100%	2024 оны жилийн эцсийн байдлаар иргэний улсын бүртгэлийн 23588 бүртгэлийн 60683 хуудас эх нотлох баримтыг цахимжууллаа.	100
2.6	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийг хууль тогтоомж холбогдох журмын дагуу хөтлөх	-	Үзүүлсэн бүртгэлийн үйлчилгээний тоо, хувиар	100%	100%	2024 оны жилийн эцсийн байдлаар 3 бүртгэлийн хууль журмыг хэрэгжүүлэн иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, бүртгэлийг үнэн зөв хөтөлж, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 23588 иргэнд, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 21022 иргэнд, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 3612 иргэнд тус тус бүртгэлийн үйлчилгээг 100 хувь үзүүллээ.	100
2.7	Шинээр байгуулагдсан 4 багт нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж иргэдийн		Шилжилт хөдөлгөөн бүртгэлийн тоо	0	100%	17 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, хариуцсан багийн бүртгэгч нар Найрамдал багт-1552,	100

	шилжилт хөдөлгөөний бүртгэлийг газар дээр нь очиж бүртгэх		хувиар			Чандмань багт-1248, Чингэл багт-972, Баян-Овоот багт-1032 иргэний шилжилт хөдөлгөөнийг газар дээр нь очиж бүртгэн иргэний шилжилт хөдөлгөөнийг 100 хувь бүртгэж баталгаажууллаа.	
2.8	Мэдээллийг дотоодод болон гадагшаа түгээх, ил тод байдлыг хангах хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах		Хамтарсан хэвлэл мэдээллийн тоо	12 телевиз	12 телевиз, 4 сайт	Улсын бүртгэлийн ерөнхий газраас баримталж буй бодлого шийдвэрийг албан хаагчдад 7 хоног бүрийн шуурхай зөвлөгөөн дээр болон ажлын дотоод группэд байнга тавьж мэдээлж байна. /жилийн байдлаар 61 мэдээ мэдээллийг 100 хувь/ гадаад паспорт, тоон гарын үсэг авах болон Монгол улсын их хурал, орон нутгийн сонгуультай холбоотой мэдээллийг пэйж хуудас болон фейсбүүкээр контент хэлбэрээр иргэдэд хүргэсний зэрэгцээ Номин телевиз, ETV телевиз, Тусгал телевиз, Гэрэгэ сайт, Эрдэнэт-Инфо сайтуудаар 18 удаагийн мэдээлэл, 1 удаагийн хэвлэлийн бага хурал зохион байгууллаа. Үүнд: Сонгогчийн шилжилт хөдөлгөөний мэдээлэл, нэрсийн жагсаалттай танилцах, нэрсийн жагсаалтад гомдол гаргах, шинэ хоршоо хөдөлгөөний тухай, түүнийг хэрхэн бүртгүүлэх тухай мэдээлэл иргэдэд хүргэж ажиллалаа.	100
<b>Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.</b>							

3.1	Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны материалыг программд тухай бүр нь оруулах	-	Цахим системд оруулсан хэрэг маргааны тоо хувиар	100%	100%	Тайлант хугацаанд хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа 2 хэргийн материалыг хяналт шалгалтын зөрчлийн нэгдсэн санд бүртгэлээ.	100
3.2.	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах зорилгоор хяналт шалгалтыг эрчимжүүлэх, зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлагын арга хэмжээ авах	-	Хяналт шалгалт хийсэн бүртгэлийн үйлчилгээний тоо хувиар	0	100%	Жилийн эцсийн байдлаар шинээр байгуулагдсан 358 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэл болон нэмэлт өөрчлөлт хийлгэсэн 616 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг цахим санд шалгахад зөрчил илрээгүй бөгөөд эцсийн өмчлөгчөө бүртгүүлэх тухай мэдээллийг хэлтсийн пэйж болон орон нутгийн зарын том сайт болох Эрдэнэт-Инфод байнга мэдээлж байна.	100
3.3	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	100%	100%	Төлөвлөгөөний дагуу иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-5772, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр-480, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр-950, архивын чиглэлээр- 1403 бүртгэлд тус тус байнгын болон түүвэрчилсэн шалгалт хийж мэдээ тайланг Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллалаа. Тайлангийн хугацаанд 7202 бүртгэлийн шалгалтаас 11 зөрчил илрүүлж зөрчлийг тухай бүр нь залруулж арилгалаа.	100
3.4	Архивын эх нотлох баримт цахимжуулах, лавлагаа олгох үйл ажиллагаанд хяналт тавих	-	Архивын эх нотлох баримтад хийсэн хяналт шалгалтын тоо хувиар	0	100%	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн эх нотлох баримт цахимжуулах үйл ажиллагаанд хяналт тавьж 10336 бүртгэлийн нотлох баримт, иргэн хуулийн этгээдэд олгосон 1403 лавлагааны эх	100



						нотлох баримт, ХААТР маягтын цахимжилтанд хяналт шалгалт хийлээ. Илэрсэн зөрчилгүй хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.	
3.5	Зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх		Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо хувиар	100%	100%	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20 д заасан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж зөрчил үйлдсэн 155 иргэн, 4 хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлыг хүлээн авч 6025000 төгрөгийн торгууль оногдуулж шийдвэрийг прокурорт хянуулж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.	100
3.6	Мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдалд хяналт тавьж албан хаагчдаас нууцын баталгаа гаргуулж авах, хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	100%	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу дотооддоо 4 удаа сургалт зохион байгуулж мэдээллээр хангаж ажиллалаа. Сургалтыг улсын бүртгэгч Н.Алтанцэцэг, мэдээлэл технологийн ажилтан Б.Лхамцэрэн болон Орхон аймаг дахь Хүний эрхийн үндэсний комиссын ахлах мэргэжилтэн Ц.Батзаяа нар явууллаа. Мэдээллийн сангийн нууцлал аюулгүй байдлыг хангах үүднээс 17 бүртгэгч, 2 архивчаас нууцын баталгаа гаргуулан авлаа. Хууль хяналтын байгууллагаас ирүүлж буй албан бичгийн хариуг олгох ажлыг Ахлах бүртгэгч нараар гаргуулан ажиллаж байна.	100

						Бүртгэгч бүр компьютер ашиглалтын дэвтэр хөтөлж, албан хаагчдын хариуцсан тоног төхөөрөмжид код, лац хийж бүртгэлжүүлээ.	
3.7	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах	-	Байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо,  Тайлагнаж, байршуулсан мэдээллийн мөнгөн дүн /сая/	148  983,68	148  -	2024 оны жилийн байдлаар шилэн дансанд байршуулах 148 мэдээнээс 148 мэдээг цаг хугацаанд нь байршууллаа. Батлагдсан төсөв нь 1097,49 сая төгрөг, төсвийн гүйцэтгэл нь 983,68 сая төгрөг нийт гүйцэтгэл нь 90 хувьтай төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй үр дүнтэй зарцуулж байна.	100
3.8	Үндэсний аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх	-	Зөвлөмж, акт, албан шаардлагын тоо, биелэлтийн хувь.	100%	100%	Аудитын газраас өгсөн 2 зөвлөмж, 2 актыг 100 хувь барагдуулж мэдээ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлээ.	100
3.9	Улсын бүртгэлийн үйлчилгээний талаар “Хэрэглэгчийн үнэлгээ” хийлгэх ажлыг зохион байгуулах		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	0	100%	Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлын төлөвлөгөө гарган, биечлэн 65 иргэнээс, цахимаар 78 иргэнээс үнэлгээний саналыг авч нэгтгэлээ. Тус хэлтсийн албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүйд анхаарч төрийн албаны шударга, ил тод байдлыг ханган ажиллах тал дээр ажил зохион байгуулах, үйлчилгээний танхимын иргэдэд тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг сайжруулах, бүртгэлийн байгууллагын байртай болгох талаар ахиц дэвшил гаргах, бүртгэгч нарын ур чадварыг сайжруулах гэсэн асуудлыг иргэд хөндөж тавьсан. Цаашид иргэдийн тавьсан асуудлыг	100

						шийдвэрлэж сайжруулахаар ажил төлөвлөөд байна.	
3.10	Архивын улсын үзлэгт бэлтгэх, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Архивын ажлын төлөвлөгөөний дагуу иргэний архивд- 12707, эд хөрөнгийн архивд – 19103, хуулийн этгээдийн архивд – 5600, байгууллагын архивд – 34 хадгаламжийн нэгж, нийт 37444 хадгаламжийн нэгжүүдэд үзлэг хийж сэргээн засварлах шаардлагатай болон шинээр нэмэгдсэн хувийн хэргийг дугаарлан шинэчилсэн. Архивын стандарт шаардлагыг хангах зорилгоор, өдөр бүр чийгшил, гэрэлтүүлэг, утаа мэдрэгч, галын булан цэвэрлэгээ үйлчилгээнд тогтмол хяналт тавьж сейф тавиурын бүрэн бүтэн байдалд байнга үзлэг шалгалт хийж бүртгэл хөтөлж байна.	100
3.11	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн тайлан мэдээ хүргүүлэх	-	Хүргүүлсэн тайлан мэдээний тоо	12	12	Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газар болон аймгийн статистикийн хэлтэст 30 төрлийн мэдээг сар улирлаар үнэн зөв гаргаж хуулийн хугацаанд нийт 12 удаа хүргүүллээ.	100
3.12	Тоног төхөөрөмж, сүлжээний аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах	-	Хийсэн хяналт шалгалтын тоо	0	4	Мэдээлэл технологийн ажилтан хэлтсийн серверийн өрөөний аюулгүй байдал, лац хэвийн эсэхэд тогтмол хяналт тавьж тэмдэглэл хөтөлж байна. 2024 оны эхэнд Тагнуулын албаны мэргэжилтэн, мэдээлэл технологийн ажилтан нар хамтарч бүртгэгчдийн ашиглаж буй тоног төхөөрөмжид шалгалт хийлээ. Лац ломбо хэвийн, асаах кодыг тогтмол	100

						шинэчилж хэвшсэн байна. Мөн гэр хорооллын нэгдсэн үйлчилгээний төв, Жаргалант сумын сүлжээний байдалд үзлэг хийлээ. Илэрсэн зөрчилгүй үйл ажиллагаа хэвийн ажиллаж байна.	
3.13	Цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажиллах	-	Сүлжээний аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахад авсан арга хэмжээ, үзлэг шалгалтын тоо	2	4	Мэдээллийн нэгдсэн сүлжээний байдалд хяналт тавьж ажиллахад 2024 оны жилийн эцсийн байдлаар 21 удаа сүлжээ тасарч, системд хурууны хээ танигдахгүй хадгалагдахгүй 6 удаа доголдох зэрэг бүртгэлийн үйл ажиллагаанд саад гарч, асуудлыг тухай бүрд нь Мэдээлэл технологийн газарт мэдэгдэж доголдол саадыг арилгаж бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа. Хэлтсийн 22 албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж байгаа цахим мэдээллийн сангийн хадгалалт хамгаалалт, нууцлалын аюулгүй байдлыг хангасан эсэхэд 2 удаа, ашиглалтын дэвтэр хөтлөлтөд 8 удаа шалгалт хийж аюулгүй байдлыг ханган ажиллалаа.	100
<b>Зорилт 4. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.</b>							
4.1	Монгол улсын их хурлын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах.	-	Төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан хувь	0	100%	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан сонгуулийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Улсын их хурлын сонгуулийн ажлыг зохион байгуулах хэлтсийн төлөвлөгөө гарган ажиллалаа. 50 ажил төлөвлөж цаглабарт ажлуудыг хуулийн	100

						хугацаанд 100 хувь хийж гүйцэтгэлээ.	
4.2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах	-	Төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан хувь	0	100%	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан мэдээллийг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлж, хэсэг оноолт, сонгогчдын нэрийн жагсаалт, лавлагаа үүсгэх, шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох, программын сургалт явуулах, хэсгийн хороодод сонгогчдын нэрийн жагсаалт хүргүүлэх, сонгуулийн тоног төхөөрөмж татан авах зэрэг хугацаатай ажлуудыг цаг хугацаанд нь бүрэн дүүрэн хийж гүйцэтгэлээ.	100
<b>Зорилт 5. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.</b>							
5.1	Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Тус хэлтсийн төрийн захиргааны 18 албан хаагчаас хуульд заасан хугацаанд ХАСХОМ мэдүүлгийг хүлээн авч нэгтгэн Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн. Төрийн захиргааны албан хаагчийн сэлгэн ажиллуулах журмын хүрээнд тус хэлтэст Булган аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын бүртгэгч Саруул нь томилогдон ажиллаж байна. Төрийн албанд тушаал дэвшүүлэн ажиллах, солих журмын хүрээнд 2 албан хаагчийг тушаал дэвшүүлэн томилсон. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээг Засгийн газрын 301 дугаар тогтоолын дагуу үнэлж дүгнэхийн	100

						<p>зэрэгцээ, төрийн албаны мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3 албан хаагчийг үнэ төлбөргүй суралцууллаа.</p> <p>Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдлын хүрээнд хэлтсийн цахим хуудсыг 95% дүгнүүлсэн. <a href="http://www.shilen.gov.mn">www.shilen.gov.mn</a> бөгөөд шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулж байна.</p> <p>Одоогийн байдлаар цаг хугацаанд нь оруулах 148 мэдээллээс 148 мэдээлэл бүрэн оруулсан. <a href="http://www.shilendans.com">www.shilendans.com</a></p>	
5.2	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг тогтмол шинэчилж, бүртгэл хөтлөх	-	Бүртгэгдсэн эцсийн өмчлөгчийн тоо хувиар	100%	100%	Шинээр бүртгэгдсэн 358 аж ахуйн нэгж, нэмэлт өөрчлөлт хийлгэсэн 616 аж ахуйн нэгжийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг тухай бүр нь 100 хувь шинэчлэн бүртгэж баталгаажууллаа.	100
5.3	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	-	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас	100%	100%	Авлигатай тэмцэх газраас болон Улсын бүртгэлийн ерөнхий газраас гаргаж буй олон нийтэд зориулсан 21 сурталчилгааны материалыг өөрийн пэйж хуудас болон Аймгийн Засаг даргын тамгын газрын сайтад 9 удаа байршуулан олон нийтэд хүргэсэн. <p>Тус хэлтсийн үйл ажиллагаа, албан хаагчтай холбоотой авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг байгууллагын 70358989 утсаар болон Авлигатай тэмцэх газрын 110 болон 1800-1969 дугаартай утас, <a href="http://www.iaas.mn">www.iaas.mn</a> веб сайт, <a href="mailto:contact@iaas.mn">contact@iaas.mn</a> цахим хаягаар авах тухай Орхон аймгийн улсын бүртгэлийн</p>	100

			болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо хувиар			цахим хаяг болон үйлчилгээний танхимд самбарт байршуулан ил тод мэдээллээ. Мөн авлига ашиг сонирхлоос ангид байх тухай контент гарган нийтийн сүлжээнд сурталчиллаа.	
			Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулсан тоо	2	4	Хэлтсийн албан хаагчдад авлига хүнд суртлаас ангид байх талаарх 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, 1 видео контент бэлтгэн нийгмийн сүлжээгээр олон нийтэд хүргэн түгээн сурталчилсан. Хэлтсийн албан хаагчдын өрөөний хаалга, үйлчилгээний танхимын цонх бүрд авлигаас урьдчилан сэргийлэх наалт бүхий тэмдэглэгээг иргэдэд харагдахуйц байдлаар байршуулснаар авлигаас ангид байх, урьдчилан сэргийлэх нэг нөхцөлийг бүрдүүлсэн.	
<b>Зорилт 6. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.</b>							
6.1	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан “Нийгмийн баталгаа хангах” хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдын нийгмийн асуудлыг шат дараатай тавьж шийдвэрлүүлэх	-	Хөтөлбөр хэрэгжилтийн тоо	2	3	Нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын 83 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж тасралтгүй 5 жил ажилласан албан хаагчдад урамшуулал олгох баримтыг бүрдүүлэн, судалгааг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүүгийн газарт хүргүүлж 15 албан хаагчдад 115172 мянган төгрөгийн урамшууллыг олголоо.	100

						Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024.10.02-ны өдрийн А/164 тоот тушаалаар албан хаагчдын хоол унааны нөхөх төлбөрийг шинэчлэн тогтоох тухай тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж 11 сарын 01 өдрөөс эхлэн албан хаагчдын хоол унааны зардлыг 25 мянган төгрөг болгож нэмэгдүүллээ. Мөн албан хаагчдын ажлаа тайван хийх нөхцөлийг бүрдүүлж цэцэрлэгт хүүхдээ өгөх авах үед хүүхэд амрах, тоглох тусгай өрөө гаргаж тохижууллаа.	
6.2	Байгууллагын ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөн ажиллах		Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2	4	Хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажлын цаг ашиглалтыг өдөрт 4 удаа бүртгэж, ажилласан цалин хөлсийг нь хуулийн дагуу олгож байна. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу цалинтай чөлөө-8 албан хаагчид, цалингүй чөлөөг -25 албан хаагчид тус тус олголоо. Байгууллагын ёс зүйн дүрмийн хэм хэмжээг баримтлан хууль ёсыг дээдлэн сахиж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах тухай 2 удаагийн сургалт дотооддоо зохион байгууллаа. Мөн сэтгэл зүйн тест авч бүлгийн сургалт зохион байгууллаа.	100
6.3	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний биелэлт хувь	100%	100%	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго 8 зорилт 48 арга хэмжээ төлөвлөж гүйцэтгэлийн төлөвлөгөөг 100 хувьтай хэрэгжүүлсэн бөгөөд цаг үеийн компани т ажлыг зохион байгуулалтын өндөр түвшинд	100



						хийж гүйцэтгэлээ.	
6.4	Байгууллагын 2024 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100%	100%	Улсын бүртгэлийн ерөнхий газрын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан хэлтсийн 2024 оны сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд 57 сургалт болон дотооддоо зохион байгуулсан 8 сургалтад 29 албан хаагч бүрэн хамрагдлаа.	100
6.5	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд бүрэн хамруулах	-	Даатгалд хамрагдсан улсын бүртгэгчийн тоо	0	6	Улсын бүртгэлийн ерөнхий газраас эд хөрөнгийн 6 бүртгэгчийг хариуцлагын даатгалд бүрэн хамруулсан.	100
6.6	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах	-	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тоо хувиар	100%	100%	Тайлангийн хугацаанд 28 өргөдөл, санал хүсэлт ирснийг хуулийн хугацаанд нь 100 хувь шийдвэрлэж хариу өглөө.	100
6.7	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэхтэй холбоотой сургалт зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах		Сургалтад хамрагдсан бүртгэгчийн тоо	0	6	Барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар хийх сургалтыг дотооддоо зохион байгуулж эд хөрөнгийн 6 бүртгэгчийг хамрууллаа. Тайлант хугацаанд 309 барьцаа дуусгавар болгох бүртгэлийн цахим бүртгэлийг хийлээ.	100
6.8	Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох сургалт зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан бүртгэгчийн тоо	0	6	Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн өмчлөх эрхийн гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх сургалтыг зохион байгуулж сургалтад аймгийн нотариатчидын танхимын төлөөлөл-6, 18-бүртгэгч бүрэн хамрагдлаа.	100

6.9	Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэх зуучлалын системийн талаар бүртгэгч болон тойргийн нотариатч нарыг мэдээ мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан бүртгэгч, нотариатчидын тоо	0	14	Тойргийн 16 нотариатчидтай 1 удаагийн сургалт зохион байгуулж, зуучлалын систем бүртгэлийн талаар санал солилцлоо. Нотариатч нарт бүртгэлийн хууль дүрэм журмаас танилцуулж бүрдүүлбэр үнэн зөв байх үндсэн шаардлагуудыг танилцуулж гарын авлага материал тараалаа. Нотариатч нар сканер, компьютерыг сүлжээнд холбоход бэлэн байгаа бөгөөд нотариатын танхимаас 1 удаагийн сургалт зохион байгуулж Улсын бүртгэлийн ерөнхий газартай үнэ хөлсний асуудал шийдэгдэхэд бүртгэл хийх нөхцөл нь бүрдсэн байна.	100
6.10	Иргэд болон аж ахуйн нэгжүүдэд бүртгэлийн хууль, дүрэм журам, цахим үйлчилгээний танилцуулга сургалт зохион байгуулах		Явуулсан сургалтын тоо	1	3	Баян-Өндөр сумын 26 багийн Засаг дарга, зохион байгуулагч нарт Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуулиар 2 удаагийн сургалт зохион байгуулж мэдээллийг иргэдэд хүргэж хамтран ажиллахаар боллоо. Тоон гарын үсгийн тухай хуулиар “Эрдэнэт Үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 980 албан хаагчид, “Ачит Ихт” ХХК, “Эрдмин” ХК, Авто тээврийн байгууллага, Хот тохижуулах газрын ажилчид, сургууль цэцэрлэгийн эрхлэгч нарт давхардсан тоогоор 1800 -д иргэнд хууль журмыг сурталчилж хүргэлээ.	100
6.11	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг		Зохион байгуулсан	0	1	Иргэний улсын бүртгэлийн эрсдэл бууруулах сургалтыг ахлах бүртгэгч Ө.Ганзориг, эд	100

	бууруулах сургалт зохион байгуулах		сургалтын тоо			хөрөнгийн бүртгэлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтыг эд хөрөнгийн ахлах бүртгэгч С.Жамбалсүрэн нар тус бүр 1 удаа зохион байгуулж зөвлөмж зөвлөгөө өглөө.	
6.12	Хэлтсийн 2024 оны үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний сургалт зохион байгуулах	-	Сургалтын тоо, илэрсэн эрсдлийн тоо	0	1	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хамтын ажиллагаа сургалтын хэлтэст эрсдэлийн үнэлгээний сургалт авах санал хүргүүлж 2024.10.25-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бодлого төлөвлөлт дүн шинжилгээний газраас явуулсан сургалтад хэлтсийн нийт албан хаагчид буюу 29 албан хаагч бүрэн хамрагдлаа. Тус хэлтэст илэрсэн эрсдэл нь эд хөрөнгийн бүртгэлийн архив подвалын давхарт байршиж байгаа нь том эрсдэлийг дагуулж байна.	100
6.13	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт албан хаагчдыг бүрэн хамруулах		Хамруулсан албан хаагчдын тоо хувиар	0	25	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн “Эрүүл мэндийг дэмжих” төвд 29 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулж албан хаагчид өөрсдийн хариуг авч эмчилгээ сувилгаанд хамрагдлаа.	100
6.14	Бүртгэгч нарыг иогийн дасгал, фитнес хамруулж хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх		Хамруулсан албан хаагчдын тоо хувиар	0	18	7 хоног бүрийн 5 дахь өдөр албан хаагчдыг иогийн дасгал, фитнес өөрсдийн сонирхлоор хамруулж, хөдөлгөөний дутагдал өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж байна.	100
<b>Зорилт 7. Бусад асуудлаар</b>							

7.1	Орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах, уялдаа холбоо сайжруулах	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	0	3	Аймгийн Засаг Даргын Тамгын газартай хамтран ажиллаж бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор зөврийн 4G тоног төхөөрөмжийг худалдан авч бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. Орхон аймгийн Хуулийн эрх зүйн хэлтэстэй хамтран ажиллаж иргэдэд хуулийн сурталчилгааг 7 удаа зохион байгууллаа. Мөн хамтран ажилладаг хууль хяналтын байгууллагуудын дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж тус хэлтсийн баг 3 дугаар байр эзэллээ. Байгууллагын дарга нарыг урьж хамтран ажиллах уулзалт зохион байгуулж санал солилцлоо.	100
7.2	Бүртгэгчдийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор бүртгэлийн хуулиар илтгэлийн уралдаан зохион байгуулах	-	Хамрагдсан албан хаагчдын тоо	0	20	“Бүртгэлийн хууль журмыг хэрэгжүүлэх явцад үүсэж буй зөрчил, түүнийг хэрхэн зохицуулах вэ” сэдэвт уралдаан зарласан бөгөөд удирдамжийг бүртгэгч нарт хүргүүлж, шалгаруулалт явуулахад тус хэлтсийн улсын бүргэгч О.Сарангэрэл тэргүүн байр эзэллээ.	100
<b>Зорилт 8. “Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд</b>							
8.1	Монгол бичгийн мэдлэг чадвараа дээшлүүлэхээр бие даан суралцах, сургалтад хамрагдах	-	Бие даан суралцсан сургалтын тоо	1	2	Монгол бичгийн анхан шатны онлайн хичээлийг үзэж судаллаа.	100
8.2	Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон аймаг орон нутгаас зохион байгуулсан онлайн болон танхимын сургалтад хамрагдах	-	Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон аймаг	100%	100%	Тайлант хугацаанд хэлтсийн албан хаагчид нийт 57 сургалтад хамрагдсан бөгөөд, дотоод нөөц бололцоогоо ашиглан 8 удаа, Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион	100

	хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	орон нутгаас зохион байгуулсан сургалтын тоо хувиар		байгуулсан 24, бусад чиглэлээр 10 сургалт зохион байгуулсан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдсан 7:4:10 сургалтад нийт 15 удаа хамрагдсан. “Монгол улсын хөгжлийн бодлого ба төрийн байгууллагын стратегийн төлөвлөлт”, “Монгол улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал”, “Төрийн албан хаагчдад зориулсан нэгдсэн сургалт”-д мэдээлэл технологийн ажилтан Б.Лхамцэрэн, Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад бүртгэгч Д.Баярмаа, М.Жавзансүрэн, ахлах түшмэлийн сургалтад Ө.Ганзориг нар хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүллээ.	
--	------------------------------------	---	--	---	--

---oOo---